



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 40

Номгон

Цагаатгах ажлыг удирдан зохион
байгуулах аймгийн салбар комисс
шинэчилэн томилох тухай

Монгол Улсын Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг, Ерөнхийлөгчийн 2002 оны 39 дүгээр зарлигийн хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дүрэм”-ийн 4 дүгээр бүлгийн 21 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах аймгийн салбар комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчилэн томилсугай.

Дарга: Ц.Отгонбаяр-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга

Нарийн бичгийн дарга: Д.Юндэнбазар-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны Олон нийттэй харилцах хэлтсийн дарга

Гишүүд: С.Байгалмаа-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

М.Мөнхдаваа-Баянхонгор аймаг дахь Эрүү, иргэний давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгч /өөртэй нь зөвшилцсөнөөр/

В.Эрдэнэчимэг-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн архивын тасгийн дарга

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 117 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах аймгийн салбар комиссын дарга /Ц.Отгонбаяр/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР



D:/2018/Alban bichig/th togtool-2019

0113263